МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ДАШЗЭГВИЙН АМАРБАЯСГАЛАН
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2015.01.24 № 3Ф-1/22

танай _____-ны №_____-т

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000254000835

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025. 01. 22 № ХЗГ/213

танай _____-ны №_____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.БААСАНДОРЖ ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Танай 2025 оны ТГ-01/98 дугаар албан бичгийн дагуу Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийг ханган холбогдох материалыг дахин хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлохыг хүсье.

Хавсралт 209 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ

900255002770

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
Т Э М Д Э Г Л Э Л Э Э С

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 44 дүгээр тэмдэглэлд:

“8.ХЭЛЭЛЦСЭН нь: Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

ШТА1206-9023100394-5498449

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2025.1.17 № 1/283

танай _____-ны №_____-т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.

О.АЛТАНГЭРЭЛ

151605309
А5.файл.2024

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД
Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.12.23 №01/10512

танай 2024.12.20-ны №1/2457 -т

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД О.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761003522

БАТЛАВ
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД **О.АЛТАНГЭРЭЛ**

ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл:

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.” гэж, Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалтад “Монгол Улсын иргэн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно” гэж, Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад “Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх үндсэн үүрэгтэй.” гэж, ”Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”гэж тус тус заасан.

Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4.3 дахь заалтад заасны дагуу иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг байхаар, Эрүүгийн хуулийн 1.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байхаар тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 5.5.7-д “Засаглалын үйл ажиллагаанд иргэд эрх тэгш оролцон үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх боломж, чадавхыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлэх орчныг бүрдүүлнэ.”гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 24 дүгээр тогтоолоор батлсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.1.3 дахь заалтад “Иргэний улс төрийн эрх, эрх чөлөөг бүрэн хангах баталгааг бүрдүүлж, жагсаал, цуглаан хийхэд зөвшөөрөл олгох тогтолцоог хална. Жагсаал, цуглааны төрөл, хэлбэрүүдийг хүлээн зөвшөөрч, уг эрхээ эдэлсний төлөө хууль бусаар мөрдөн хавчигддаггүй, үндэслэлгүйгээр хууль зүйн хариуцлагад татагддаггүй байх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэж заасан.

Практик шаардлага:

Монгол Улсын Их Хурлаас Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийг 1994 онд анх баталсан бөгөөд түүнээс хойш нийт 7 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Тухайлбал, 2006 онд Сүхбаатарын талбайд хоноглох, гэр, майхан, унаа хөсөг оруулахгүй байх зохицуулалт нэмсэн, 2015 онд жагсаал, цуглаан зохион байгуулахад зөвшөөрөл олгодог байсныг мэдэгдэл хүргүүлэх, гэхдээ хариу заавал авах зохицуулалттай болгосон, 2015 онд Зөрчлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан өөрчлөлт оруулсан, 2017 онд Гамшгаас хамгаалах тухай хууль батлагдсантай холбогдуулан гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед хориглох хүрээг өргөжүүлсэн агуулгаар өөрчилсөн, 2014 онд жагсаал, цуглааныг албадан тараах үйл ажиллагаанд зөвхөн дотоодын цэргийн нэмэлт хүч хэрэглэхээр заасныг үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудаас дэмжлэг авч болох тухай, 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр жагсаал, цуглааныг зохион байгуулах мэдэгдлийг бичгээр хүргүүлэх, 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр хориглох байршлыг төрийн тусгай хамгаалалтын байнгын бүс байхаар нэмсэн зэрэг өөрчлөлтийг тус тус оруулсан байдаг.

Дээрх нэмэлт, өөрчлөлтүүдээс харахад бүхэлдээ үзэл бодлоо илэрхийлэх, жагсах, цуглах эрхийг хязгаарлах чиглэлээр, албадан тараах үйл ажиллагаанд хүч нэмэгдүүлсэн агуулгаар шинэчлэгдэж ирсэн гэж үзэж болохоор байна.

Дэлхийн банкны засаглалын судалгааны иргэдийн дуу хоолой ба хариуцлагын үнэлгээгээр Монгол Улсын индекс 2022 оны байдлаар 56.039 байгаа бөгөөд 192 орноос 79-д эрэмбэлэгдсэн байна. Засаглалын индексийг Дэлхийн банк 1996 оноос тооцож эхэлсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд Монгол Улсын тус индексийн дундаж 56.65 бөгөөд тус үзүүлэлтэд ямар нэг ахиц гараагүй байна.

Монгол Улсад жагсаал, цуглаан зохион байгуулагдаж ирсэн тоо баримтыг сүүлийн 8 жилийн байдлаар авч үзвэл 2014 онд 115, 2015 онд 140, 2016 онд 121, 2017 онд 128, 2018 онд 180, 2019 онд 206, 2020 онд 255, 2021 онд 214, 2022 онд 241, 2023 онд 254, 2024 оны 8 дугаар сарын байдлаар 155 удаагийн жагсаал, цуглааныг иргэд, олон нийтийн зүгээс зохион байгуулж, мөн цагдаагийн байгууллага хуулиар хүлээсэн үүргийн дагуу уг үйл ажиллагааг болон оролцогчдын аюулгүй байдал, дэг журмыг хангуулан ажиллажээ.

2014-2022 онд иргэд нийт 38 удаа өлсгөлөн зарлаж Эрүүл мэндийн сайдын 2010 оны 233 дугаар тушаалаар баталсан “Өлсгөлөнгийн үед эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар”-ын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлсэн тоон үзүүлэлттэй байна. Түүнчлэн, сум, дүүргийн Засаг даргаас сүүлийн 2 жилд 214 жагсаал, цуглаан зохион байгуулахыг хүссэн бичигт цар тахлын үеийн дүрэм, журмын зохицуулалттай холбоотойгоор татгалзсан хариуг өгсөн байдаг.

Жагсаал, цуглааны тоо өсөхийн хэрээр зохион байгуулагдах хэлбэр, хүрээ хязгаар нь ч харилцан адилгүй болж байгаа бөгөөд ийнхүү шинээр үүсэж байгаа нөхцөлд нийцсэн зохицуулалт дутагдаж байна. Иргэний тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг баталгаажуулах ёстой хуулийн зарим зохицуулалтууд нь өөрөө хүний эрхийг хязгаарлах, зөрчих үндэслэл нь болж байна.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээгээр тулгамдаж байгаа дараах асуудлуудад дэвшилтэт зохицуулалтыг бий болгох шаардлагатай гэж дүгнэсэн:

1.Иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх эрхийн хэрэгжилт нь тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй салшгүй холбоотой. Нийгмийн харилцааны өөрчлөлтөд үндэслэн гудамж, талбайд жагсаал цуглаан зохион байгуулахад зөвшөөрөл олгодог хуулийн зохицуулалтыг өөрчилж, бүртгэлийн зохицуулалттай болгох зорилгоор Улсын Их Хурлаас 2005 онд нэмэлт, өөрчлөлтийг баталсан боловч жагсаал, цуглаан зохион байгуулахдаа Засаг даргад мэдэгдэл хүргүүлж, бүртгүүлэх зохицуулалт нь "зөвшөөрөл"-тэй адил байдлаар хэрэглэгдэж, иргэдийн тайван жагсаал, цуглаан хийх эрхийг хязгаарлаж байна.

Түүнчлэн, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактад "Тайван хуран цуглах эрхийг хүлээн зөвшөөрнө. Энэхүү эрхийг эдлэхэд ардчилсан нийгэмд үндэсний буюу нийгмийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах, эрх ашгийн үүднээс хуулийн дагуу тогтоосноос өөр хязгаарлалт хийж болохгүй." гэж заасан.

Ийнхүү жагсаал, цуглаан хийх эрх нь зөвхөн нийтийн дэг журмыг хөндөхүйц бодитой үндэслэл байвал хязгаарлагдаж болох хэдий ч захиргааны байгууллагаас "зөвшөөрөхгүй байх үндэслэл"-ийг хэт өргөн утгаар тайлбарлаж, жагсаал, цуглаан хийх эрхийг хязгаарлаж байна. Түүнчлэн, цар тахалын эсрэг холбогдох хуулиудаар нийслэлийн Засаг даргад тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хязгаарлах эрх олгоогүй байхад захирамж баталж, иргэдийн жагсаал, цуглаан хийх эрхийг хязгаарлаж, жагсаалыг бүртгэхгүй байх, түүнийг зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулсан зэрэг хүний эрхийг зөрчсөн цөөнгүй тохиолдол гарсныг судлаачид тэмдэглэсэн байдаг.

Иргэд цахим орчинд идэвхтэй болж, аливаа мэдээллийг түргэн шуурхай хүлээн авснаар нийгмийг бухимдуулсан үйл явдал, мэдээлэлд богино хугацаанд хариу үйлдэл, эсэргүүцэл үзүүлдэг болсон өнөө цагт жагсаал, цуглаан зохион байгуулахын тулд жагсаал зохион байгуулахаас 3 өдрийн өмнө Засаг даргад мэдэгдэл өгөх , түүний дагуу мэдэгдлийг бүртгэсэн эсэх хариуг Засаг дарга ажлын 3 өдрийн дотор өгөх, хэрэв бүртгэхээс татгалзсан бол шүүхэд хандаж болох боловч шүүх ажлын 6 өдрийн дотор Засаг даргын татгалзал үндэслэлтэй эсэхийг шийдвэрлэх ёстой. Үүнээс харахад жагсаал, цуглаан хийх мэдэгдлээ бүртгүүлж цуглаан хийхэд нийт ажлын 9 өдөр буюу хуанлийн 14 хоног зарцуулахаар байна. Энэ талаар гадаадын зарим орны сайн туршлага байна. Жишээ нь ХБНГУ-ын хувьд мэдэгдэл өгсний дараа зохион байгуулагч нь зөвшөөрөл авах шаардлагагүй тул эрх бүхий байгууллагаас ямар нэгэн хариу хүлээх ёсгүй байдаг байна. Түүнчлэн тодорхой цөөн тооны иргэн мэдэгдэл хүргүүлэхгүйгээр цуглаж үзэл бодлоо илэрхийлж болдог зохицуулалт зарим улсад байдгийг харгалзан үзэх нь зүйтэй байна.

Иймд жагсаал, цуглаан хийх үндсэн эрхээ эдлэхэд тухайн засаг захиргааны нэгжид бүртгүүлдэг, бүртгэсэн эсэх талаар хариу авдаг зохицуулалт үйлчилж байгааг өөрчлөх шаардлагатай байна.

2.Цаг үеийн асуудлаас үүдэн иргэд зохион байгуулалтгүйгээр, тухайн үйл явдал болсон дариуд нэгдэн цуглаж, жагсах тохиолдол байдаг. Энэ төрлийн жагсаал, цуглааныг хууль бус буюу бүртгүүлээгүй жагсаал, цуглаанд тооцож байна. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд жагсаал, цуглааныг зохион байгуулах, бүртгүүлэх, жагсаал, цуглааны хэлбэрүүд болох сөрөг жагсаал, аяндаа үүссэн жагсаал, цуглааны талаарх хуулийн зохицуулалт байхгүйгээс жагсаал, цуглааныг зохион байгуулагчид үүрэг ногдуулсан байдал нь иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлах, эрхийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний хамрах хүрээнд төлөвлөсөн болон зохион байгуулсан, төлөвлөөгүй буюу аяндаа үүссэн олон төрлийн үйл явдал ордог. Хэн нэг хүний хэлсэн үг, бусдын хийсэн цуглаан, эсхүл тодорхой үйл явдалд хариу болгон зохион байгуулсан цуглааныг аяндаа үүссэн цуглаанд тооцож хүлээн зөвшөөрөх нь олон улсын гэрээ конвенцод нийцнэ. Ийм цуглааны үед зохион байгуулагч байхгүй, эсхүл зохион байгуулагч байсан ч урьдчилан мэдэгдэл өгөх хуулийн хугацааг баримтлах боломжгүй байдаг. Аяндаа үүссэн цуглаан нь тодорхой үйл явдлын өрнөлийн үед аяндаа бий болдог. Ийм цуглааныг хийх боломжтой байх нь чухал бөгөөд түүнийг хойшлуулснаар илэрхийлэх гэж буй үзэл бодлыг сулруулдаг. Иймд Монгол Улсад аяндаа үүссэн жагсаал, цуглааныг хүлээн зөвшөөрөх шаардлагатай.

3.Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлд жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдэл хүлээн авах, хянаж хариу өгөх, жагсаал цуглааныг албадан тараах шийдвэрийг гаргах эрх бүхий этгээд нь аймаг, нийслэлийн Засаг дарга буюу улс төрийн албан тушаалтан байдаг. Ийнхүү манай улсад жагсаал, цуглаан зохион байгуулахад бодит байдал дээр зөвшөөрлийн тогтолцоо үйлчилж байгаа бөгөөд жагсаалын зорилго, агуулгад Засаг дарга субъектив байдлаар хандаж жагсаалыг үл зөвшөөрөх, цаашлаад албадан тараах шийдвэр гаргахад хүртэл нөлөөлөх тохиолдлууд гардаг талаар олон нийт шүүмжлэлтэй хандаж байна.

Жагсаал, цуглааны үеэр жагсагчидтай хамгийн ойр ажилладаг, тэдгээрийг зохион байгуулах, аюулгүй байдлыг хангах, хэв журмыг хангуулах, хуульд заасан бол тараах үүргийг цагдаагийн байгууллага хэрэгжүүлдэг. Иймээс гадаадын бусад орны жишиг АНУ, Франц, Япон гэх зэрэг улсын жагсаал, цуглаан зохион байгуулах зохицуулалтын туршлагаас үзэхэд тухайн орон нутгийн төрийн тусгай алба буюу цагдаагийн байгууллагад хандах, мэдэгдэх тогтолцоотой байна. Харин төрийн тусгай алба болон Засаг даргын тамгын газар хоорондоо олон нийтийн газар болох үйл явдлын талаар мэдээллийг солилцож харилцан уялдуулдаг байх боломжтой юм.

4.Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар жагсаал, цуглааныг хориглох үйл ажиллагааг субъект, газар байршил, зорилго чиглэл, хугацаа зэргээр нь төрөл бүрийн хэлбэрээр хязгаарлаж зохицуулсан байна.

Хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцын дагуу тайван жагсаал, цуглаан зохион байгуулахад дээр дурдсан хүрээ хязгаар тогтоож, түүнийг хууль тогтоомжоор өргөжүүлэхгүй байхыг зөвлөдөг. Иймхүү тогтоосон хориглолт, хязгаарлалт нь хүний тайван хуран цуглах үндсэн эрх чөлөөг хангаагүй гэж үздэг байна.

Манай улсын хувьд Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд байршлаар нь нисэх онгоцны буудал, төмөр замын бүх өртөө, буудал, нийслэлийн зорчигч тээврийн төв буудал, цэрэг, цагдаагийн болон төрийн хамгаалалтад байгаа газар, радио телевизийн нэвтрүүлэг явуулдаг байгууллага, аймаг, нийслэл дэх төв холбооны газар, олон улсын буюу үндэсний яармаг, үзэсгэлэн зохион байгуулж байгаа байгууллага, хот суурин газрын хүнсний болон барааны зах, Нийслэл Улаанбаатар хотын Сүхбаатарын талбайн Төрийн ордны нутаг дэвсгэрт хамаарах хэсэгт гэж хориглосноос гадна бусад хуулиар хориглох хүрээг өргөжүүлэн тусгасан байдаг. Тухайлбал, Монгол Улсын хилийн тухай хуулиар хилийн боомт, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулиар яаманд, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулиар агентлагт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар хорих ангид, Төрийн ордны тухай хуулиар төрийн ордон, түүний нутаг дэвсгэрт хориглохоор тус тус заасан.

Хүний эрхийн олон улсын байгууллагуудын зөвлөмжид жагсаал, цуглаан хийхийг хориглох байршлыг хавтгайруулж тогтоох нь зохисгүй гэж үздэг байна. Гэхдээ дээрх хуулиар хориглосон байршилд дурдагдаагүй зарим байршлын тухай шинээр авч үзэх боломжтой. Тухайлбал, замын хөдөлгөөний зорчих хэсэг, гүүрэн байгууламж зэргийг судлан тусгаж болох зэргээр улс орныхоо нөхцөл байдалд тохируулан хэрэглэх боломжтой байна. Өөрөөр хэлбэл, тухайн байршилд жагсаал, цуглаан зохион байгуулах тохиолдолд эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн байх зохицуулалтыг бий болгох шаардлагатай. Харин бусад байршилд зөвхөн мэдэгдэл хүргүүлснээр буюу хариу хүлээх шаардлагагүйгээр тайван хуран цуглах эрхээ хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

Түүнчлэн хориглох субьектээр нь авч үзвэл хуулиар Монгол Улсын иргэн, улсын бүртгэлд бүртгэгдсэн улс төрийн нам, төрийн бус байгууллага жагсаал, цуглаан зохион байгуулах эрхтэй гэж тусгайлан тоочиж хүрээ хязгаарыг зааж өгсөн нь эдгээрээс бусад этгээдийг хориглох агуулгыг илэрхийлж байна.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд сэтгэцийн өвчтэй хүнийг, Төрийн албаны тухай хуулиар төрийн албан хаагчийг, Төрийн тусгай албаны тухай хуулиар төрийн тусгай албаны ажилтанг, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулиар цэргийн албан хаагчийн жагсаал, цуглаан хийх эрхийг хориглох, эсхүл хязгаарласан байна.

Иймд дээрх субьектүүдэд тогтоосон хориглолт, хязгаарлалтыг Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээнд нийцүүлэн дахин авч үзэх, ингэхдээ хүрээ хязгаарыг аль болох багасгаж олон улсын гэрээнд нийцүүлэх шаардлагатай.

5.Монгол Улс хүний эрх, эрх чөлөөний асуудлаар нийт 48 гэрээ конвенцод нэгдэн орсон байдаг ч олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж байгаа гэж Хүний эрхийн Үндэсний Комисс дүгнэсэн байдаг.

Цагдаа, хууль сахиулах байгууллагын алба хаагчид хүчин төгөлдөр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлсний төлөө олон улсын гэрээ конвенцын өмнө буруутан болох учиргүй. Иймд цагдаагийн байгууллагаас жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний мөн чанар, үүссэн зөрчлийг хэлэлцээний аргаар шийдвэрлэх ур чадварыг цагдаагийн алба хаагчдад төлөвшүүлэх нь чухал. Энэ хүрээнд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Цагдаагийн ерөнхий газар болон Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага хамтран жагсаал, цуглааны үед хууль сахиулахад хүний эрхийг хангах асуудлаар цагдаагийн сургагч багш нар бэлдэж, энэ чиглэлээр боловсруулсан гарын авлагыг практикт үр дүнтэй ашиглаж байгаа нь сайшаалтай.

Ийнхүү тайван жагсаал, цуглаан хийх эрхийн баталгааг хүний эрхийн аливаа зөрчилгүйгээр хангах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, хууль ёсоор тайван жагсаал, цуглаанд жагсагч болон цагдаа нарыг сөргөлдүүлэн тавих бус хамтран ажиллах, хоорондоо идэвхтэй харилцаатай байх, мэдээлэл солилцох, зөвлөн туслах харилцаатай байхыг дэмжих чиглэлээр эрх зүйн орчинг өөрчлөх шаардлагатай байна.

Ингэхдээ мэдэгдлийн тогтолцоог хэрэгжүүлэх, жагсаал, цуглааныг албадан тараахдаа эрх хэмжээг хэтрүүлэхгүй байх, жагсагчидтай тохирсон харилцаа үүсгэх, дэмжих-хамтрах-зохицуулах-хянах-сануулах-тараах-хүч хэрэглэх гэсэн дарааллыг баримтлах, Засаг даргын захирамжийг үндэслэн тараадгийг өөрчилж зөвхөн хуульд заасан үндэслэлээр эрх бүхий этгээд албадан тараах, түүнчлэн албадан тараах нөхцөл боломж буюу тодорхой хугацааны өмнө мэдэгдэх, албадан тараасны дараа энэ талаар олон нийтэд мэдээлэл өгөх зэрэг зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

6.Жагсаал, цуглаан түүнтэй холбоотой мэдээллийг ил тод байхад чиглэсэн арга хэмжээг тусгах шаардлагатай. Тухайлбал, жагсаал цуглааны үйл явц олон нийтэд нээлттэй байх, ялангуяа хэвлэл мэдээллийн хэрэгслийн сурвалжлах, хөндлөнгийн ажиглалт, хяналт тавих боломжийг бүрдүүлэх, албадан тараах үйл ажиллагааны талаарх мэдээлллийг олон нийтэд тусгайлан мэдээлдэг байх зохицуулалт бий болгох нь зүйтэй.

7.Иргэд үзэл бодлоо илэрхийлэх нэг хэлбэр болох өлсгөлөн, өлсгөлөн зарласан этгээдийг албадан эмчлэхтэй холбоотой асуудлыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар зохицуулж байна. Энэ нь нэг талаар хүний үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хүлээн зөвшөөрч байгаа ч нөгөө талаар тухайн этгээдийн эрүүл мэнд, амь насыг хамгаалах нь хүнлэг ёс, төрийн үйл ажиллагааны нэг хэлбэр байх учиртай. Тус журмаар хүний эрхэд хязгаарлалт хийж байгаа зохицуулалтыг хуульд тодорхой тусгаж шийдвэрлэх нь зүйтэй байна.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн нэр нь иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрхийг журамлах агуулгатай байна. Иймд хуулийн нэрийг өөрчилж Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай гэж боловсруулна.

Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа

Хуулийн төсөл нь 6 бүлэг 16 зүйлтэй байх бөгөөд дараах асуудлыг тусган боловсруулна.

Нэгдүгээр бүлэг.Нийтлэг үндэслэл хэсэгт хуулийн зорилт, Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, нэр томьёоны тодорхойлолт, жагсаал, цуглааны үйл ажиллагаан дахь зарчим;

Хоёрдугаар бүлэг.Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөө. Зохион байгуулах, оролцох эрх, эдгээр эрхийн баталгааны талаар;

Гуравдугаар бүлэг.Жагсаал, цуглаан зохион байгуулах, мэдэгдэх үйл ажиллагаа, зохион байгуулагч, оролцогчийн эрх,үүрэг;

Дөрөвдүгээр бүлэг.Жагсаал, цуглаан зохион байгуулах хориглолт, хязгаарлалт буюу жагсаал, цуглаан хийхийг хориглох газар, зорилго, жагсаал, цуглааны бусад хязгаарлалт;

Тавдугаар бүлэг.Оролцогчийн аюулгүй байдлыг хангах, нийгмийн дэг журмыг хангуулах, жагсаал, цуглаан, түүнд оролцогчдыг хамгаалах, эрх бүхий этгээдээс хариу үзүүлэх үйл ажиллагаа, албадан тараахтай холбоотой зохицуулалт;

Зургадугаар бүлэг.Бусад зохицуулалт. Жагсаал зохион байгуулах үйл явц, нээлттэй ил тод байх, гомдол гаргах, өлсөлөн, суулт, түүнтэй холбоотой зохицуулалт, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын талаар.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактад заасан иргэдийн тайван хуран цуглах эрх бүрэн хангагдаж, зөвхөн хуульд заасан үндэслэлээр энэхүү эрхийг хязгаарлах зохицуулалт баталгаажна.Цуглааны хэлбэрүүдийг хүлээн зөвшөөрнө. Жагсаал, цуглааны хориглолт, хязгаарлалтын хүрээ хязгаар тодорхой болно. Хуульд зааснаас бусад аливаа хэлбэр, тухайлбал, захиргааны хэм хэмжээний актаар хязгаарлах боломжгүй болно.

Жагсаал, цуглаан зохион байгуулахад бүртгүүлэх үүрэгтэй, эрх бүхий байгууллага бүртгэсэн тохиолдолд жагсаал, цуглаан хийх эрхтэй болох зохицуулалт үйлчилж байгаа байдал хязгаарлагдаж, зөвхөн онцгой нөхцөл байдал, зайлшгүй хориглох цөөн тохиолдлоос бусад тохиолдолд цагдаагийн байгууллагад мэдэгдэл хүргүүлснээр жагсаал, цуглаан зохион байгуулах боломж бүрдэнэ.Цагдаагийн байгууллагаас олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийгмийн дэг журмыг

сахиулахдаа хүний эрхийн зөрчил гаргахгүй байх, хууль ёсны тайван жагсаал, цуглаанд жагсагч болон цагдаа хамтран ажиллах, хоорондоо идэвхтэй харилцаатай байх, мэдээлэл солилцох, зөвлөн туслах нөхцөл бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуульд нийцүүлэн боловсруулна. Хуулийн төсөлтэй холбогдуулан Дайны байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дотоодын цэргийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийг тус тус боловсруулна.

---oOo----

ТАНИЛЦУУЛГА /Товч/

Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний
тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын илтгэлүүдэд /2002 оны 1 дэх, 2004 оны 3 дахь, 2009 оны 9 дэх, 2010 оны 10 дахь, 2020 оны 20 дахь, 2022 оны 22 дахь/ тусгасан мэдээлэл дүгнэлт, зөвлөмж, хуулийн хэрэгжилтийн талаар "Эмнести интернэшнл" төрийн бус байгууллагаас гаргасан тайлан, дүгнэлт, зөвлөмж, Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооноос 2021 оны 12 сард зохион байгуулсан Жагсаал, цуглаан зохион байгуулах журмын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэг, нэр бүхий Улсын Их Хурлын гишүүдийн санаачилсан Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан зарим асуудал зэргийг үндэслэн хуулийн төслийг дараах байдлаар боловсруулаад байна.

1.Жагсаал, цуглаан санаачлан зохион байгуулах этгээдийн хүрээг өргөжүүлэх буюу Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага санаачлах, зохион байгуулах, оролцох эрхтэй байх;

2.Хүчин төгөлдөр хуульд жагсаал, цуглаан зохион байгуулах, санаачлах асуудал нь тодорхой хүрээ хязгаартай, тухайлбал улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар гэж тусгайлан заасныг өөрчилж, ямар ч асуудлаар жагсаал, цуглаан хийж болохоор нээлттэй байх;

3.Аяндаа бий болсон жагсаалыг мэдэгдэл хүргүүлсэн жагсаалын адил хүлээн зөвшөөрөх, зэрэгцсэн жагсаал, эсрэг жагсаал зохион байгуулахыг хязгаарлахгүй байх, тэдгээрийн аюулгүй байдлыг хангах, хэв журам хамгаалах;

4.Бүртгүүлэх нэртэй боловч зөвшөөрөл авдаг тогтолцоог халж, жагсаал, цуглааныг зөвхөн авто замын зорчих хэсэгт зохион байгуулах бол урьдчилан мэдэгдэж, хариу авсны үндсэн дээр, хуулиар хориглосноос бусад газар зөвхөн мэдэгдэл хүргүүлснээр зохион байгуулах боломж бүрдүүлэх;

5.Мэдэгдэл хүлээн авах, хариу өгөх, хууль бус жагсаал, цуглааныг албан тараах эрх бүхий этгээд нь Засаг дарга буюу улс төрийн албан тушаалтан байгааг цагдаагийн байгууллага, тухайн шатны Засаг даргын Тамгын газар хэрэгжүүлэхээр өөрчлөх;

6.Нийтийн хэв журмыг хангах, үндэсний аюулгүй байдал, бусад этгээдийн аюулгүй байдлыг хангах шаардлагаар зөвхөн хуулиар /байршил, зорилго, агуулга, субьект, цаг хугацаа /хориглолт, хязгаарлалтыг тавихыг хүлээн зөвшөөрнө. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулиас гадна бусад хуулиудаар зохицуулсан энэ хуулийн төсөлд нэгтгэн тусгаж зайлшгүйгээс бусад хориглолт, хязгаарлалтыг аль болох багасгах, жагсаал, цуглаан хийх эрхийг хориглосон, хязгаарласан агуулгатай захиргааны акт баталж мөрдүүлэхийг хориглох;

7.Зөвхөн хуульд заасан үндэслэлээр, тараах үндэслэл гарцаагүй бий болсон нь тогтоогдсон гэж үзсэн тохиолдолд албадан тараах, ингэхдээ тус ажиллагааг баримтжуулах, урьдчилан сануулах, оролцогчдын хувийн байдалд тохирсон арга хэмжээ авах, аль болох хамгийн бага хүч хэрэглэх аргыг сонгох, цагдаагийн байгууллага тус ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэл өгдөг байх;

8.Жагсаал, цуглааныг сурвалжлах, мэдээлэх эрхэд хязгаарлалт тавихгүй байх, жагсаал, цуглаан зохион байгуулах, оролцох эрхийг зөрчиж байгаа гэж үзсэн тохиолдолд захиргааны байгууллага, Хүний эрхийн Үндэсний Комисс, шүүхэд гомдол гаргах эрх нээлттэй байх.

Хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамны mojha.gov.mn сайтад 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр байршуулан санал авах болон 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр 60 гаруй оролцогчтой хэлэлцүүлэг зохион байгуулах зэргээр олон нийтийн оролцоог хангаж ажилласан болно.

----oOo----

ТАНИЛЦУУЛГА /Дэлгэрэнгүй/

Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний
тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээний тайлан, Хүний эрхийн Үндэсний Комиссоос боловсруулсан Хүний эрх, эрх чөлөөний байдлын илтгэлүүдэд тусгасан жагсаал цуглааны талаарх судалгаа, мэдээлэл, дүгнэлт мэдээлэл, зөвлөмж, "Эмнести интернэшнл" төрийн бус байгууллагаас Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийг шинэчлэн сайжруулахтай холбоотой тус байгууллагаас хийсэн дүгнэлт, тайлан, Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооноос 2021 оны 12 сард зохион байгуулсан Жагсаал, цуглаан зохион байгуулах журмын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэг, түүнчлэн нэр бүхий Улсын Их Хурлын гишүүдийн санаачилсан Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан зарим асуудал болон бусад материалыг үндэслэн хуулийн төслийг боловсруулаа.

Ийнхүү жагсаал, цуглаан болон түүний төрөл, хэлбэрүүдийг хүлээн зөвшөөрсөн агуулгаар шинээр томьёолох, жагсах, цуглах эрх чөлөөнд үндэслэлгүйгээр хязгаарлалт тавихгүй байх, Монгол Улсын хууль тогтоомжид тусгагдаагүй аяндаа үүссэн жагсаал, цуглааны талаарх зохицуулалт, түүнчлэн жагсаал, цуглаан хийх мэдэгдэл хүргүүлэх, бүртгүүлэх үйл ажиллагаанд дэвшилтэд зохицуулалт бий болгох, хууль сахиулах нийтийн дэг журмыг хангах чиг үүрэг бүхий байгууллагаас гүйцэтгэх үйл ажиллагааны хүрээ хязгаарыг тодорхой болгох зэрэг зохицуулалтыг дараах байдлаар тусгалаа.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактад тайван хуран цуглах эрхийг баталгаажуулан заасан байдаг бөгөөд ингэхдээ тайван болон тайван бус жагсаал, цуглааныг ялгаатай байдлаар ойлгож пактын хүрээнд зөвхөн тайван жагсаал, цуглаан хийх эрхийг хамгаалдаг. Иймд хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, эд хөрөнгөд эрсдэл учруулахуйц байдлаар зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглааныг тайван бус гэж, үүнээс бусдаар тааламжгүй нөхцөл байдалтай байсан ч хүмүүс хүлцэх боломжтой нөхцөл байдал бүхий жагсаал, цуглааныг тайван гэж тус тус тодорхойлсон.

Мөн иргэд хуран цуглаж үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй бөгөөд, энэ нь олон төрлийн хэлбэрээр илрэн гарч болдог тул хоёр ба түүнээс дээш тооны хүн ижил зорилгоор нийтийн эзэмшил эсхүл, хувийн өмчлөлийн газарт цуглаж, үзэл бодол, санал шаардлагаа илэрхийлж байгаа үйл ажиллагааг цуглаан гэж, хоёр ба түүнээс дээш тооны хүн хот, суурингийн гудамж, талбайгаар зохион байгуулалттайгаар жагсан явж үзэл бодол, санал, шаардлагаа илэрхийлэх үйл ажиллагааг жагсаал гэсэн агуулгаар тус тус томьёолж, харин жагсаал, цуглааныг суулт, өлсгөлөн зарлах болон хуулиар хориглоогүй бусад хэлбэрээр зохион байгуулж болохоор тусгаад байна.

Хуулийн зорилго, чиг үүргийг хэрэгжүүлэхэд эрх зүйн зарчим шийдвэрлэх нөлөө үзүүлж, тэдгээрийн гол эх үндэс нь болдог[1] талаар судлаачид дүгнэсэн байдаг. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд үйл ажиллагаандаа баримтлах зарчим тусгагдаагүй байдаг. Иймд хуулийн төсөлд тайван жагсаал, цуглаан хийх замаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх эрхээ эдлэх болон хууль сахиулах байгууллагаас нийтийн

[1] Д.Баярсайхан. Эрх зүйн онол УБ 2020 он 50 дахь тал

хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хуульд зааснаас гадна ялгаатай үзэл бодлыг хүлээн зөвшөөрөх, хүчирхийллээс ангид байх, мэдээлэл нээлттэй, ил тод байх зэрэг зарчмуудыг тусгалаа.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд төрийн ёслолын болон төрийн эрх бүхий байгууллагаас зохион байгуулж байгаа жагсаал, цуглаанд тус хууль хамаарахгүй байхаар заасан. Энэ нь жагсаал, цуглааныг бүртгэнэ гэсэн зохицуулалттай боловч төрийн байгууллага өөрөө бүртгүүлэхгүй хийж болохоор зохицуулсан байгаа талаар 2004 оны Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаарх 3 дахь илтгэлд дурдагдсан байдаг. Иймд тус хууль нь төрийн эрх бүхий байгууллагаас зохион байгуулж байгаа хүндэтгэл болон ёслолын жагсаал, цуглаан, хүн, хуулийн этгээдээс зориулалтын байгууламж болон олон нийтийн газар зохион байгуулж байгаа спорт, урлаг, соёл урлаг, үзэсгэлэн худалдаа, бизнесийн үйл ажиллагаа болон тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээ, төрийн байгууллага, нийтийн эрх зүйн этгээдээс зохион байгуулж байгаа хурал, уулзалт, хэлэлцүүлэг, мэдээлэл болон үйлчилгээ үзүүлэх өдөрлөг болон тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээ, улс төрийн нам, эвсэл, сонгуульд нэр дэвшигчээс иргэн, сонгогчидтой, төрийн бус байгууллагаас гишүүн, дэмжигчидтэй хийх хурал, уулзалт зэрэгт хамаарахгүй байхаар тусгалаа.

Хүчин төгөлдөр Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд жагсаал, цуглаан хийх эрхийг зөвхөн тодорхой тооны этгээд санаачлах, зохион байгуулах агуулгаар буюу Монгол Улсын иргэн, улсын бүртгэлд бүртгэгдсэн улс төрийн нам, төрийн бус байгууллага зохион байгуулах эрхтэй байхаар заасан. Өөрөөр хэлбэл эдгээр этгээдээр хязгаарлаж байгаа нь олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцыг зөрчсөөр байна. Иймд хуулийн төсөлд Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага жагсаал, цуглааныг санаачлах, зохион байгуулах, оролцох эрхтэй байхаар өргөжүүлэн тусгалаа.

Түүнчлэн хүчин төгөлдөр хуульд жагсаал, цуглаан зохион байгуулах, санаачлах асуудал нь тодорхой хүрээ хязгаартай, тухайлбал улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар гэж тусгайлан заасныг өөрчилж, ийнхүү тухайлан сэдэв, асуудал тусгахгүйгээр ямар ч асуудлаар жагсаал, цуглаан хийж болохоор нээлттэй тусгаад байна.

Жагсаал, цуглаан хийх хэлбэрүүдийг хүлээн зөвшөөрөх

Тайван хуран чуулах эрх чөлөөг хэрэгжүүлэх хууль ёсны арга хэлбэрүүд буюу аяндаа үүссэн цуглаан, давхацсан ба эсрэгцсэн, давталттай цуглаан, үл захирагдахуйн акц зэргийг хуульд тусгахыг Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын 22 дахь илтгэлээрээ зөвлөсөн байдаг.

Тодорхой үйл явдал болсон даруйд эрх бүхий байгуулагад бүртгүүлэх боломжгүй, тодорхой зохион байгуулагчгүй жагсаал, цуглаан нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байдгийг манай улс хориглож, бүртгүүлээгүй гэх үндэслэлээр хууль бусад тооцох тохиолдол гарсаар байна. Иймд “аяндаа бий болсон жагсаал”-ыг цагдаагийн байгууллага мэдэгдэл хүргүүлсэн жагсаалын адил хүлээн зөвшөөрч, тэдгээрийн аюулгүй байдлыг хангах, хэв журам хамгаалах зэрэг үүрэг хүлээхээр тусгасан. Ийм төрлийн жагсаалд заавал мэдэгдэл хүргүүлэхийг шаардах, зохион байгуулагчтай байхыг шаардах боломжгүй юм. Харин жагсаал, цуглааны явцад зохион байгуулалтад орох тохиолдол байдаг тул энэ тохиолдолд хамгийн боломжит хурдан хугацаанд зохион байгуулагч нь эрх бүхий байгууллагад мэдэгдэх зохицуулалтыг тусгалаа. Энэ нь аяндаа үүссэн гэх шалтгаанаар нийтийн эмх

замбараагүй байдал бий болохоос урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журмыг сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаанд нэмэр болох, цаашлаад иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулахаас сэргийлэх зорилготой.

Хүчин төгөлдөр Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулиар зохих журмын дагуу бүртгэгдсэн жагсаал, цуглаан хийх газарт мөн цаг хугацаанд түүний эсрэг агуулга, зорилготой өөр жагсаал, цуглаан давхардуулан хийхийг хориглосон байдаг. Харин хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ижил асуудлаар, тухайн цаг хугацаанд өөр өөр газарт, эсхүл өөр асуудлаар ижил газарт жагсаал, цуглаан зохион байгуулах, түүнд оролцох эрхийг хязгаарлахгүй, жагсаал, цуглаан зохион байгуулж байгаа тухайн асуудлын эсрэг байр сууринаас үзэл бодлоо илэрхийлж жагсаал, цуглаан зохион байгуулах эрх, түүнд оролцох эрхийг хязгаарлахгүй байхаар өөрчлөн тусгасан нь иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангахад дэвшилтэт зохицуулалт болно гэж үзэж байна.

Мэдэгдэх, бүртгэх тогтолцоо

Хуулийн төслийн нэгэн чухал зохицуулалт бол жагсаал, цуглаан хийхийн тулд аймаг, нийслэлийн Засаг даргаас бүртгэл нэртэй боловч бодит байдал дээр зөвшөөрөл авдаг байдлыг халах зорилгоор хуульд хориглохоор заасан байршлаас бусад газар жагсаал, цуглаан хийх бол цагдаагийн байгууллагад мэдэгдэл хүргүүлснээр жагсах, цуглах эрх нээлттэй болох юм. Өөрөөр хэлбэл, авто замын зорчих хэсэгт жагсаал, цуглааныг зохион байгуулахаар бол урьдчилан мэдэгдэж, хариу авсны үндсэн дээр, харин хуулиар хориглосноос бусад газар зөвхөн мэдэгдэл хүргэснээр буюу ямар нэг хариу хүлээх шаардлагагүйгээр жагсаал, цуглаан зохион байгуулах боломж бүрдэх юм.

Ингэхдээ замын хөдөлгөөнд саад учруулах боломжтой, авто зам дээр жагсаал, цуглаан хийх бол бүртгүүлж, жагсаал, цуглаан хийж болох эсэх талаар хариу авахаар тусгасан. Учир нь ийм байршилд хийгдэх жагсаал, цуглаан нь тухайн бүс нутгийн авто замын хөдөлгөөнд оролцогч нийт иргэдийн өдөр тутмын амьдралд хамаарах асуудал болох тул хөдөлгөөнд зохицуулалт хийх, мэдээлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжийг судлах шаардлагын үндсэн дээр ирүүлсэн мэдэгдлийг хянах нь зүйтэй гэж үзсэн. Ийм зохицуулалт бүхий Эстони зэрэг орон бий.

Мөн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн дагуу бүх төрлийн жагсаал, цуглааныг бүртгэх зохицуулалт байдаг. Харин шинэ хуулийн төслөөр иргэдийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх, эрх чөлөөг илүү нээлттэй байдлаар зохицуулах зорилгын үндсэн дээр аяндаа үүссэн жагсаал, цуглаан, өлсгөлөн, суулт зарлах тохиолдлуудад мэдэгдэл хүргүүлэх шаардлагагүй байдлаар тусгаж өгсөн.

Түүнчлэн 2004 оны Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаарх 3 дахь илтгэлд жагсаал, цуглаан зохион байгуулах талаарх мэдэгдлийг Засаг дарга буюу улс төрийн албан тушаалтан хүлээн авч бүртгэж байгаа нь субьектив хандлагыг бий болгож байгаа бөгөөд Засаг даргын бүртгэхээс татгалзах үндэслэл тодорхой бус байдаг явдал нь шүүмжлэл дагуулдаг талаар дурдсан.

Ийнхүү бүртгэх эрх бүхий субьект улс төрийн албан тушаалтан байгаа нь субьектив хандлага гаргах магадлалыг бий болгодог тул жагсаал, цуглааны үеэр тэдэнтэй хамгийн ойр ажилладаг, хууль сахиулах, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангуулах эрх бүхий байгууллага буюу цагдаагийн

байгууллагад энэхүү эрхийг олгохоор тусгаад байна. Дэлхийн улс орнуудад энэ чиг үүргийг ихэнх тохиолдолд хууль сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах байгууллага хэрэгжүүлдэг бөгөөд ХБНГУ зэрэг улсуудад байдаг үр дүн бүхий зохицуулалт юм.

Хориглолт, хязгаарлалт

Хуулиар хориглох жагсаал, цуглааны агуулгад Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 20 дугаар зүйлд заасан дайныг аливаа хэлбэрээр сурталчилах, алагчилан дайсагналцах болон хүчирхийллийг өдөөн турхирдаг үндсэрхэг үзлээр, арьс үндсээр болон шашин шүтлэгээр үзэн ядах байдлыг дэмжсэн аливаа ухуулга сурталчилгаа хийхийг хуулиар хориглох гэх агуулгуудыг оруулж өгсөн.

Түүнчлэн тайван замаар жагсаал, цуглаан хийх эрхийг хориглох, хязгаарлах үндэслэл болдог Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 21 дүгээр зүйлд дурдсан дараах зорилгуудыг тусгасан. Үүнд:

1.үндэсний аюулгүй байдлыг хамгаалах

2.нийгмийн аюулгүй байдлыг хамгаалах

2.нийгмийн дэг журмыг хангах

3.хүн амын эрүүл мэндийг хамгаалах

4.ёс суртахууныг хамгаалах

5.бусдын эрх эрх чөлөөг хамгаалах

Хүний эрхийн гэрээ, конвенцоор жагсаал цуглаан хийхийг хориглох, хүрээ хязгаарыг аль болох багасгах, бууруулах чиглэлд ажиллахыг зөвлөдөг бөгөөд дээр дурдсанчлан нийгмийн дэг журмыг хангах, үндэсний аюулгүй байдал, бусад этгээдийн аюулгүй байдлыг хангах шаардлагаар зөвхөн хуулиар хориглолт, хязгаарлалтыг тавихыг хүлээн зөвшөөрдөг. Иймээс олон улсын гэрээ конвенцод нийцүүлэн өөрийн орны онцлогт тохирсон тодорхой хязгаарлалтыг тавих нь зүй ёсны хэрэг билээ. Манай улс жагсаал, цуглаанд байршлаар нь, зорилго, агуулгаар нь, субьектээр нь , цаг хугацаагаар нь хязгаарлалт тавьдаг хэдий ч зөвхөн Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд бус, бусад хуулиудаар мөн тус хязгаарлалтуудыг зохицуулсан байна. Иймээс бусад хуульд заасан хориглосон, хязгаарласан зохицуулалтыг энэ хуулийн төсөлд нэгтгэн тусгах зарчмыг баримталсан тул энэ нь шинээр хориглолт, хязгаарлалыг нэмсэн асуудал огт биш бөгөөд зөвхөн хууль зүйн техникийн үүднээс нэгтгэсэн болохыг энд дурдах нь зүйтэй. Тухайлбал, байршлын хувьд Монгол Улсын хилийн боомт, нисэх онгоцны буудал, төмөр замын өртөө, буудал, эмнэлгийн байгууллага, Төрийн ордон, түүний нутаг дэвсгэр, хорих анги, түүний хамгаалалтын зурвас, улсын онц чухал объект, төрийн тусгай хамгаалалтын бүс зэрэг газруудад хязгаарлахаар тусгаад байна.

Жагсаал, цуглаан шөнийн цагаар, их хэмжээний дуу чимээ гаргаж үргэлжлэх, авто замын хөдөлгөөн, хүний урсгалыг зохицуулах боломжгүйгээр удаан хугацаанд хааж, саатуулах зэргийг хуулиар хориглож болно. Харин энэ төрлийн зохицуулалт нь дор тайлбарлах хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах журамд нийцэх шаардлагатай талаар Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын 22 дахь илтгэлд /2023 он/ тусгасан байдаг. Гадаадын зарим орон тухайлбал, БНСУ-д зөвхөн нар мандахаас нар жаргах хүртэлх хугацаанд жагсаал, цуглаан хийхийг зөвшөөрдөг. Учир нь

шөнийн цагаар үзэл бодлоо хүргэхээр зорьж байгаа этгээдийн ажил тарсан байх, олон нийтийн амгалан тайван байдал алдагдах, хүмүүсийн идэвхтэй байх хугацаа буурсан байх, харагдах орчин хязгаарлагдсан байх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх шаардлага нэмэгдэх зэрэг шалтгаан гардаг тул хориглодог байна.

Манай улсын хувьд жилийн 4 улиралтай, улирлаас хамааран нар жаргах, мандах хугацааны мөчлөг ихсэх, буурах үзэгдэл элбэг байдаг тул нарны гэрэл бус 06 цагаас 22 цаг хүртэл буюу шөнийн цагаар жагсахыг /үргэлжилж байгаагаас бусад тохиолдолд/ хориглох зохицуулалтыг бий болгох нь зүйтэй гэж үзлээ. "Шөнийн цаг"-ийг Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид заасантай адил байдлаар авах нь зүйтэй гэж үзэн Хөдөлмөрийн тухай хуульд тайлбарласныг эш татах байдлаар тусгалаа.

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд сэтгэцийн өвчтэй хүний жагсаал, цуглаанд оролцох эрхийг шууд бусаар хязгаарласан, сэтгэцийн өвчтэй хүн гэх ойлголтыг тодорхойлоогүй зэрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн холбогдох хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенцийг зөрчсөн хэрэг болсон талаар Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын 22 дахь илтгэлд /2023 он/ дурдсан байдаг. Иймд хөгжлийн бэрхшээлтэй хүний бусад хүмүүсийн нэгэн адил үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангах зорилгоор хуулийн төсөлд зөвхөн сэтгэцийн эмгэгийн улмаас өөрийн үйлдлийн бодит шинж чанар, аюулыг ухамсарлах, өөрийн үйлдлээ удирдан жолоодох чадваргүй хүнийг жагсаал, цуглаан зохион байгуулах, түүнд оролцохыг хуулиар хязгаарлаж болох агуулгыг тусгалаа.

Төрийн байгууллагын үйл ажиллагаа

Нийслэлийн Засаг дарга 2020 онд А/930 дугаар захирамж баталж Улаанбаатар хотын хэмжээнд цар тахлын хүрээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг шилжүүлсэн хугацаанд жагсаал, цуглаан хийхийг хориглож, олон жагсаал, цуглааныг тус захирамжид үндэслэн бүртгэхээс татгалзсан явдал нь үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хууль бусаар хязгаарласан үйлдэл болсон талаар Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын 20 дахь илтгэлд тусгасан байдаг. Түүнчлэн зарим төрийн захиргааны байгууллага жагсаал, цуглаан зохион байгуулж болохгүй хугацааг зааж, зарим хөшөөний дэргэд жагсаж, цуглаж байна гэх мэт шалтгаанаар зөвшөөрөл өгөхгүй байх тохиолдол олон гарсныг судлаачид, ялангуяа "Эмнэсти интернэшнл" төрийн бус байгууллагын "Цар тахалын үеийн хууль сахиулах ажиллагаа" сэдэвт судалгааны тайланд цагдаагийн байгууллага, албан хаагчдын үйлдсэн хүний эрхийн зөрчил, тохиолдлын судалгааны дүгнэлт, тайланд тусгаж олон нийтэд мэдээлэх болон эрх бүхий байгууллагад хүргүүлэх арга хэмжээ авсан байдаг. Иймд шинэ хуулийн төсөлд захиргааны актаар энэхүү эрхийг хориглосон хязгаарласан агуулгатай шийдвэр гаргаж, баталж мөрдүүлэхийг хориглох тухай тусгаад байна.

Түүнчлэн өлсгөлөн зарласан хүнд эмнэлгийн тусламж үзүүлэх, албадан эмчлэхтэй холбоотой харилцааг Эрүүл мэндийн сайдын 2010 оны 233 дугаар тушаалаар зохицуулж байна.

Иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх нэг хэлбэр болох өлсгөлөнгийн зохицуулалт одоо үйлчилж байгаа практикт маш хангалтгүй зохицуулагдсан талаар Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн хэрэгжилтэд хийгдсэн үр дагаврын үнэлгээ (2022 он)-нд дурдагдсан бөгөөд өлсгөлөн зарлах үед цагдаагийн болон эмнэлгийн байгууллагаас ямар чиг үүрэгтэй оролцох тухай нарийвчилсан зохицуулалт шаардлагатай гэдгийг онцолсон. Энэ хүрээнд өлсгөлөн зарласан

этгээдийн эрүүл мэндийн байдалд нутаг дэвсгэрийн эмнэлгийн байгууллага үзлэг хийж, дүгнэлт гаргах, хэрэв өлсгөлөн зарласан этгээдийн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрахаар байгаа нь тус дүгнэлтээр тогтоогдсон бол нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн газрын дарга нь өлсгөлөнг зогсоож, албадан эмчилгээнд оруулах арга хэмжээ авах шийдвэрийг гаргаж, эмнэлгийн байгууллагад хүргэх ажлыг зохион байгуулах зохицуулалтыг тусгаад байна.

Хуулийн төсөлд мөн хууль бус жагсаал, цуглааныг албадан тараах зохицуулалттай холбоотой зохицуулалтыг тусгаад байна. Албадан тараах үйл ажиллагаа нь хууль ёсны дагуу зохион байгуулагдаж байгаа, хуулийн төсөлд тусгасан хууль бус үйл ажиллагаа бий болоогүй, аяндаа үүсэн шинжтэй, өлсгөлөн, суулт хэлбэрээр хийгдэж байгаа жагсаал, цуглаанд хамааралгүй болно. Зөвхөн хуульд заасан үндэслэлээр, тараах үндэслэл гарцаагүй бий болсон нь тогтоогдсон гэж үзсэн тохиолдолд цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газар шийдвэрээр тус арга хэмжээ авахаар тусгалаа. Ийнхүү албадан тараах шийдвэрийг баталсан даруйд цагдаагийн байгууллага болон Хүний эрхийн Үндэсний Комисст шийдвэрийг хүргүүлэхээр мөн тусгаад байна. Ингэхдээ тус ажиллагааг баримтжуулах, урьдчилан сануулах, оролцогчдын хувийн байдалд тохирсон арга хэмжээ авах, аль болох хамгийн бага хүч хэрэглэх аргыг сонгох, иймхүү албадан тараасны дараа цагдаагийн байгууллага олон нийтэд тус ажиллагааны талаар мэдээлэл өгдөг байх зохицуулалтыг тусгалаа.

Жагсаал, цуглаанд оролцогчдын эрх, үүрэг

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд жагсагчдын бүх үүргийг зохион байгуулагчид хүлээлгэхээр заасан байдаг. Хуулийн төсөлд зохион байгуулагчид үүрэг болгосон хэсгийг боловсронгуй болгож жагсаалд оролцогчид өөрсдөө тодорхой үүрэг хариуцлагатай байх, шаардлагатай тохиолдолд зохион байгуулагч болон цагдаагийн байгууллага хамтран ажиллахаар тусгасан.

Үзэл бодлоо илэрхийлэн жагсаал, цуглаан зохион байгуулж байгаа болон оролцож байгаа этгээдүүдтэй цагдаагийн байгууллагын албан хаагчид хүндэтгэлтэй хандаж, хамтран ажиллах боломжийг бүрдүүлэхийг зорилоо.

Түүнчлэн жагсаал, цуглааны үйл явцад хяналт тавих, олон нийтийг мэдээллээр хангах үүднээс жагсаал, цуглааныг сурвалжлах, мэдээллэх эрхэд хязгаарлалт тавихгүй байх агуулга бүхий заалт мөн шинээр тусгалаа. Жагсаал, цуглаан зохион байгуулах, оролцох эрхийг зөрчиж байгаа гэж үзсэн тохиолдолд дээд шатны захиргааны байгууллагад гомдол гаргах, мөн Хүний эрхийн Үндэсний Комисс, шүүхэд гомдол гаргах эрх нээлттэй байхаар тусгалаа.

-----oOo-----

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ
/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан тайван жагсаал, цуглаан зохион байгуулах, оролцох эрх чөлөөг баталгаажуулах, жагсаал, цуглааны үед нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний хууль тогтоомж

2.1.Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль дараах харилцааг зохицуулахгүй:

3.1.1.төрийн эрх бүхий байгууллагаас зохион байгуулж байгаа хүндэтгэл болон ёслолын жагсаал, цуглаан;

3.1.2.хүн, хуулийн этгээдээс зориулалтын байгууламж болон олон нийтийн газар зохион байгуулж байгаа спорт, соёл урлаг, үзэсгэлэн худалдаа, бизнесийн үйл ажиллагаа болон тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээ;

3.1.3.төрийн байгууллага, нийтийн эрх зүйн этгээдээс зохион байгуулж байгаа хурал, уулзалт, хэлэлцүүлэг, мэдээлэл болон үйлчилгээ үзүүлэх өдөрлөг болон тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээ;

3.1.4.улс төрийн нам, эвсэл, сонгуульд нэр дэвшигчээс иргэн, сонгогчидтой, төрийн бус байгууллагаас гишүүн, дэмжигчтэй хийх хурал, уулзалт.

4 дүгээр зүйл.Нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“цуглаан” гэж хоёр ба түүнээс дээш тооны хүн ижил зорилгоор нийтийн эзэмшил эсхүл, хувийн өмчлөлийн газарт цуглаж, үзэл бодлоо илэрхийлж байгаа үйл ажиллагааг;

4.1.2.“жагсаал” гэж хоёр ба түүнээс дээш тооны хүн хот, суурингийн гудамж, талбайгаар зохион байгуулалттайгаар жагсан явж, үзэл бодлоо илэрхийлж байгаа үйл ажиллагааг;

4.1.3.”тайван жагсаал, цуглаан” гэж хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага тодорхой асуудлаар үзэл бодлоо олон нийт, төрийн байгууллагад хүргэхдээ хуулиар хориглоогүй нийтийн эзэмшил болон хувийн өмчлөлийн газарт хүчирхийллийн шинжгүй, оролцогчдын зан байдал тайван амгалан, иргэн, байгууллагын хэвийн үйл ажиллагаанд саад учруулахааргүй байгуулагдаж байгаа жагсаал, цуглааныг;

4.1.4.”хууль бус жагсаал, цуглаан” гэж энэ хуулиар хориглосон хэм хэмжээг зөрчиж зохион байгуулагдаж байгаа, эсхүл хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, эд хөрөнгөд эрсдэл учруулахуйц, хүч хэрэглэсэн байдлаар зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглааныг;

4.1.5.“өлсгөлөн” гэж ганцаар болон хамтран тодорхой асуудлаар өөрийн үзэл бодлоо илэрхийлж нийтийн эзэмшлийн эсхүл, хувийн өмчлөлийн газар өөрийн биед хоол тэжээлийг зориудаар хорьж, түүнийгээ зарлах үйл ажиллагааг;

4.1.6.“суулт” гэж ганцаар болон хамтран тодорхой асуудлаар нийтийн эзэмшлийн эсхүл, хувийн өмчлөлийн газар үзэл бодол, санал, шаардлагаа илэрхийлж хүсэлт тавин хариу сонсохоор сууж байгаа үйл ажиллагааг;

4.1.7.“аяндаа үүссэн жагсаал, цуглаан” гэж хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага тодорхой үйл явдалд хариу үзүүлэх зорилгоор тухайн үйл явдал болсон даруй хуран цуглаж үзэл бодлоо илэрхийлж байгаа үйл ажиллагааг;

4.1.8.”жагсаал, цуглаан хийх” гэж жагсаал, цуглааныг зохион байгуулах, оролцох үйл ажиллагааг.

5 дугаар зүйл.Жагсаал, цуглааны үйл ажиллагаанд баримтлах зарчим

5.1.Тайван жагсаал, цуглаан хийх замаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх эрхээ эдлэх болон хууль сахиулах байгууллагаас нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хуульд зааснаас гадна дараах зарчмыг баримтална:

5.1.1.ялгаатай үзэл бодлыг хүлээн зөвшөөрөх;
5.1.2.хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх;
5.1.3.хүчирхийллээс ангид байх;
5.1.4 мэдээлэл нээлттэй, ил тод байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ
ТАЙВАН ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЭРХ ЧӨЛӨӨ

6 дугаар зүйл.Жагсаал, цуглаан зохион байгуулах, оролцох эрх

6.1.Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага тодорхой асуудлаар үзэл бодлоо олон нийтэд, төрийн байгууллагад хүргэх зорилгоор хуулиар хориглоогүй нийтийн эзэмшил болон хувийн өмчлөлийн газарт тайван жагсаал, цуглаан /цаашид "жагсаал, цуглаан" гэх/ хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулах, түүнд оролцох эрхтэй.

6.2.Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглаанд оролцох эрхтэй.

7 дугаар зүйл.Жагсаал, цуглаан түүнийг зохион байгуулах, оролцох эрхийн баталгаа

7.1.Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага энэ хуулийн 10.1-д зааснаас бусад газарт тухайн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн аливаа үйлдэл гаргахгүйгээр жагсаал, цуглааныг зохион байгуулах эрхтэй бөгөөд энэхүү эрхийг хуульд зааснаас бусад тохиолдолд хязгаарлахыг хориглоно.

7.2.Хууль тогтоомжийн дагуу жагсаал, цуглаан зохион байгуулсан, түүнд оролцсоны төлөө хэнийг ч мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлах, аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглоно.

7.3.Энэ хуульд зааснаас бусад тохиолдолд жагсаал, цуглаан хийхэд зориуд саад учруулах, эмх замбараагүй байдал үүсгэх, хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглааныг албадан тараахыг хориглоно.

7.4.Ижил асуудлаар, тухайн цаг хугацаанд өөр газарт, жагсаал, цуглаан зохион байгуулах, түүнд оролцох эрхийг хязгаарлахгүй.

7.5.Өөр асуудлаар ижил газарт жагсаал, цуглаан зохион байгуулах, түүнд оролцох эрхийг хязгаарлахгүй бөгөөд энэ тохиолдолд жагсаал, цуглаан бүрийн аюулгүй байдлыг хангана.

7.6.Жагсаал, цуглааныг хуулиар хориглосноос бусад хэлбэрээр зохион байгуулах эрхийг хязгаарлахгүй.

7.7.Жагсаал, цуглаан зохион байгуулах, түүнд оролцохыг хязгаарласан агуулгатай захиргааны хэм хэмжээний акт баталж, мөрдүүлэхийг хориглоно.

7.8.Бусдыг жагсаал, цуглаан зохион байгуулах, түүнд оролцуулахын тулд эд мөнгөөр татах, дарамт шахалт үзүүлэх хэлбэрээр албадахыг хориглоно.

7.9.Жагсаал, цуглаанд тавих аливаа хязгаарлалт нь хүний эрхийн олон улсын хэм хэмжээнд нийцсэн байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ
ЖАГСААЛ, ЦУГЛААН ЗОХИОН БАЙГУУЛАХ, МЭДЭГДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЗОХИОН БАЙГУУЛАГЧ, ОРОЛЦОГЧИЙН ЭРХ,ҮҮРЭГ

8 дугаар зүйл.Жагсаал, цуглаан зохион байгуулах, мэдэгдэх үйл ажиллагаа

8.1.Энэ хуулийн 8.2-т зааснаас бусад газарт жагсаал, цуглааныг зохион байгуулах бол 48 цагаас доошгүй хугацааны өмнө нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад мэдэгдлийг бичгээр, эсхүл цахимаар хүргүүлнэ.

8.2.Авто замын зорчих хэсэгт жагсаал, цуглааныг зохион байгуулах бол цагдаагийн байгууллагад 72 цагаас доошгүй хугацааны өмнө мэдэгдлийг бичгээр, эсхүл цахимаар хүргүүлж, бүртгэсэн эсэх талаар хариу авсны дараа зохион байгуулна.

8.3.Энэ хуулийн 8.1, 8.2-т заасан мэдэгдэлд дараах мэдээллийг тодорхой тусгана:

8.3.1.зорилго;
8.3.2.эхлэх, дуусах хугацаа;
8.3.3.оролцогчдын тоо;
8.3.4.хэрэглэх эд зүйл;
8.3.5.цуглах, жагсан явах гудамж, чиглэл, байршил;
8.3.6.зохион байгуулагчийн нэр, хаяг, харилцах утасны дугаар.

8.4.Хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага жагсаал, цуглааны үеэр эд зүйл ашиглахдаа нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдал, бусдын эрүүл мэнд, эрх, эрх чөлөөг хүндэтгэх үүрэгтэй.

8.5.Цагдаагийн байгууллага энэ хуулийн 8.2-т заасан мэдэгдлийг хүлээн авч ажлын нэг өдрийн дотор бүртгэсэн эсэх талаар бичгээр, эсхүл цахимаар мэдэгдэнэ.

8.6.Энэ хуулийн 8.2-т заасан мэдэгдлийг бүртгэхээс татгалзсан тохиолдолд үндэслэлийг тодорхой тусгасан шийдвэрийг зохион байгуулагчид мэдэгдэнэ.

8.7.Энэ хуулийн 8.1, 8.2-т заасан мэдэгдлийг хүлээн авсан цагдаагийн байгууллага тухайн жагсаал, цуглаан зохион байгуулагч, түүнд оролцогчдын олон нийтийн газар үзэл бодол илэрхийлэх эрхийг хангах, тухайн нутаг дэвсгэр дэх замын хөдөлгөөнийг зохицуулах, олон нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журмыг хангахад шаардлагатай бэлтгэл ажлыг хангах үүрэгтэй.

8.8.Цагдаагийн байгууллага жагсаал, цуглаан зохион байгуулах мэдэгдлийг хүлээн авч зохион байгуулагчаас шаардлагатай мэдээллийг тодруулж болох бөгөөд харилцан тохиролцсоны үндсэн дээр зохион байгуулах газар, хугацаа зэрэгт өөрчлөлт оруулж болно.

8.9.Жагсаал, цуглаан зохион байгуулагч нь мэдэгдэл хүргүүлснээс хойш зохион байгуулах хүртэлх хугацаанд хэдийд ч жагсаал, цуглаан зохион байгуулахыг цуцалж болох бөгөөд энэ тохиолдолд цагдаагийн байгууллагад даруй мэдэгдэнэ.

8.10.Цагдаагийн байгууллага жагсаал, цуглаан зохион байгуулах талаарх мэдээллийг тухайн нутаг дэвсгэрт байрлах оршин суугч, байгууллагад боломжит хэлбэрээр урьдчилан мэдээлнэ.

8.11.Аяндаа үүссэн жагсаал, цуглаанд энэ хуулийн 8.1, 8.2-т заасан мэдэгдэл хүргүүлэхийг шаардахгүй.

8.12.Аяндаа үүссэн жагсаал, цуглаан нь зохион байгуулагчтай болсон тохиолдолд даруй эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

Тайлбар: - Энэ зүйлд заасан “эд зүйл” гэдэгт гэр, майхан, тээврийн хэрэгсэл, нисгэгчгүй төхөөрөмж, цахилгаан үүсгүүр, түүний дагалдах зүйлийг ойлгоно.

Тайлбар: - Энэ хуульд заасан “нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага” гэдгийг орон нутагт аймгийн цагдаагийн газар, хэлтэс, нийслэлд Нийслэлийн цагдаагийн удирдах газрыг ойлгоно.

9 дүгээр зүйл.Жагсаал, цуглааныг зохион байгуулагч, оролцогчийн үүрэг

9.1.Жагсаал, цуглаан нь энэ хуулийн 9.4-т заасныг хэрэгжүүлэх үүрэг бүхий зохион байгуулагчтай байна.

9.2.Жагсаал, цуглааныг санаачилсан, мэдэгдлийг хүргүүлсэн этгээдийг зохион байгуулагч гэж тооцно.

9.3.Зохион байгуулагч жагсаал, цуглаан зохион байгуулагдахаас өмнө дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

9.3.1.жагсаал, цуглаан зохион байгуулах үеийн хууль зүйн болон аюулгүй байдлын зөвлөмжтэй танилцах;

9.3.2.оролцогчдод энэ хуулийн 9.4-т заасан шаардлагыг урьдчилан анхааруулах;

9.3.3.энэ хуулийн 9.4-т заасан нөхцөл хангагдаагүй талаар мэдээлэл байгаа тохиолдолд цагдаагийн байгууллагад даруй мэдэгдэж шаардлагатай арга хэмжээ авах саналыг хүргүүлэх.

9.4.Жагсаал, цуглаанд оролцогч дараах үүрэг хүлээнэ:

9.4.1.жагсаал, цуглаан хийх газарт нийтийн хэв журмыг сахих;

9.4.2.бусдын эрх, эрх чөлөөг хүндэтгэж, бусдын эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулахгүй байх;

9.4.3.зэвсэг, зэвсгийн чанартай бусад зүйл, химийн хорт болон аюултай, тэсэрч дэлбэрэх бодис, шатах, тослох материал, орчиндоо аюул учруулж болох амьтныг авч явахгүй байх;

9.4.4.жагсаал, цуглааны явцад аливаа хэлбэрээр хүч хэрэглэхгүй байх;

9.4.5.согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэхгүй байх.

9.5.Жагсаал, цуглаан зохион байгуулагч, оролцогч нь жагсаал, цуглааны аль ч үед хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрхтэй.

9.6.Энэ зүйлийн 9.5-д заасан хууль зүйн туслалцааг Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 5.2.1-д заасан хэлбэрээр хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллага үзүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.
ЖАГСААЛ, ЦУГЛААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРИГЛОЛТ, ХЯЗГААРЛАЛТ,

10 дугаар зүйл.Жагсаал, цуглааныг зохион байгуулахыг хориглох газар, зорилго

10.1.Дараах газарт жагсаал, цуглаан зохион байгуулахыг хориглоно:

10.1.1.Монгол Улсын хилийн боомт;
10.1.2.Төрийн ордон, түүний нутаг дэвсгэр;
10.1.3.эмнэлгийн байгууллага;
10.1.4.нисэх онгоцны буудал, төмөр замын өртөө, буудал
10.1.5.хорих анги, түүний хамгаалалтын зурвас;
10.1.6.улсын онц чухал объект, түүний хамгаалалтын бүс;
10.1.7.төрийн тусгай хамгаалалтын бүс.

10.2.Улс орны буюу тодорхой нутаг дэвсгэрийн хэмжээнд онц болон дайны байдал зарласан, гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон бол тухайн нутаг дэвсгэрт уг шалтгаан арилах хүртэлх хугацаанд жагсаал, цуглааныг зохион байгуулахыг хуулиар хязгаарлаж болно.

10.3.Онц болон дайны байдал зарласан шалтгааныг эсэргүүцэх, гамшгийн хор уршгийг арилгах зорилгоор зохион байгуулах жагсаал, цуглаанд энэ зүйлийн 10.2 дахь хэсэг хамаарахгүй.

10.4.Дараах зорилгоор жагсаал, цуглаан хийхийг хориглоно:

10.4.1.дайныг сурталчлах, салан тусгаарлах, ялгаварлан гадуурхах, хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, төрийн эрх мэдлийг хууль бус аргаар авахыг уриалах;

10.4.2.үндэсний аюулгүй байдал, нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдалд хохирол учруулж эмх замбараагүй байдал бий болгох.

10.5.Хуулиар хориглосноос бусад зорилгоор зохион байгуулсан, эсхүл зохион байгуулагдсан жагсаал, цуглааны явцад энэ хуулийн 10.4-т заасан зорилго бүхий нөхцөл байдал бий болсон бол тухайн жагсаал, цуглааныг үргэлжлүүлэхийг хориглоно.

10.6.Жагсаал, цуглаан үргэлжилж байгаагаас бусад тохиолдолд шөнийн цагаар зохион байгуулахыг хориглоно.

10.7.Сэтгэцийн эмгэгийн улмаас өөрийн үйлдлийн бодит шинж чанар, аюулыг ухамсарлах, өөрийн үйлдлээ удирдан жолоодох чадваргүй хүн, хуульд заасан бол төрийн тусгай алба хаагчийг жагсаал, цуглаан зохион байгуулах, түүнд оролцохыг хуулиар хязгаарлаж болно.

Тайлбар: Энэ зүйлийн 10.6-д заасан “шөнийн цаг” гэдгийг Хөдөлмөрийн тухай хуулийн 88.1-д зааснаар ойлгоно.

ТАВДУГААР БҮЛЭГ

ОРОЛЦОГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, ДЭГ ЖУРМЫГ ХАНГУУЛАХ

11 дүгээр зүйл.Жагсаал, цуглаан, түүнд оролцогчдыг хамгаалах

11.1.Цагдаагийн байгууллага нь энэ хуульд заасан журмын дагуу зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглааны үед зохион байгуулагч, оролцогч иргэдийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.

11.2.Аяндаа үүссэн жагсаал, цуглааныг эрх бүхий байгууллагад мэдэгдсэн эсэх, зохион байгуулагчтай эсэхээс үл хамааран оролцогчдын аюулгүй байдлыг хангана.

11.3.Цагдаагийн албан хаагч нь хуульд заасан үүргээ гүйцэтгэхдээ жагсаал, цуглаанд оролцогчидтой хүндэтгэлтэй харьцаж, тэдгээрийн ялгаатай байдалд тохирсон арга хэмжээ авна.

11.4.Жагсаал, цуглааны явцад хүний эрх хамгаалагч, хөндлөнгийн ажиглагч хяналт тавих, ажиглалт мониторинг хийх, олон нийтийг мэдээллээр хангах, хууль зүйн туслалцаа авах боломжийг хязгаарлахгүй бөгөөд эдгээр үйл ажиллагаанд саад учруулах, хөндлөнгөөс нөлөөлөхөд чиглэсэн аливаа үйлдлийг хориглоно.

12 дугаар зүйл.Эрх бүхий этгээдээс хариу үзүүлэх

12.1.Жагсаал, цуглаан болон өлсгөлөн, суулт хийж байгаа асуудлаар хариуцах этгээд тодорхой бол тухайн эрх бүхий байгууллага, албан тушаалтан болон түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд жагсаал, цуглаан зохион байгуулагч, өлсгөлөн зарлаж, эсхүл суулт хийж байгаа этгээдийг хүлээн авч уулзах, шаардлагад хариу өгөх зэрэг хуульд нийцсэн арга хэмжээг авч болно.

13 дугаар зүйл.Жагсаал, цуглааныг албадан тараах

13.1.Жагсаал, цуглааны явцад түүний анхны зорилго өөрчлөгдөж энэ хуулийн 10.4-т заасан нөхцөл байдал үүссэн, эсхүл түүнд хүргэх эрсдэл үүсэж болзошгүй нь үндэсний аюулгүй байдлыг хангах болон хууль сахиулах байгууллагын мэдээ, баримтаар батлагдсан тохиолдолд жагсаал, цуглааныг албадан тараах үндэслэл болно.

13.2.Энэ хуулийн 10.4-т заасан жагсаал, цуглааныг зориудаар зохион байгуулсан, эсхүл хуулиар хориглоогүй жагсаал, цуглааны явцад хориглосон зорилго бүхий нөхцөл байдал бий болсон бол албадан тараах үндэслэл болно.

13.3.Жагсаал, цуглааныг зохион байгуулагч, түүнд оролцогчид энэ хуульд заасан үүргээ биелүүлээгүйгээс нийтийн хэв журам алдагдаж, эмх замбараагүй байдал бий болсон буюу хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан бол албадан тараах үндэслэл болно.

13.4.Жагсаал, цуглаан зохион байгуулагдах үеэр энэ хуулийн 10.4-т заасан үндэслэл бий болсон тохиолдолд нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга албадан тараах саналыг нийслэлийн нутаг дэвсгэрт Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, сумын нутаг дэвсгэр бол сумын Засаг даргын Тамгын газарт, хоёр ба түүнээс дээш сумын нутаг дэвсгэр дамнасан тохиолдолд аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

13.5.Тухайн шатны Засаг даргын Тамгын газар энэ хуулийн дараах шаардлагад нийцүүлэн албадан тараах тухай шийдвэр гаргаж, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс болон нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад даруй мэдэгдэнэ.

13.5.1.хуульд заасан үндэслэл журмын дагуу гаргасан байх;

13.5.2.үндэсний аюулгүй байдал, нийтийн хэв журам, нийтийн ёс суртахуун, нийтийн эрүүл мэнд, эсхүл, хүний эрх, эрх чөлөө, нэр төрийг хамгаалах зорилгод нийцсэн байх.

13.6.Жагсаал, цуглааны үеэр нэг буюу хэсэг хүн хүч хэрэглэж бусдын эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсан нь тухайн жагсаал, цуглааныг бүхэлд нь хууль бус гэж үзэж албадан тараах үндэслэл болохгүй.

13.7.Жагсаал, цуглааныг албадан тараахын өмнө зохион байгуулагч, оролцогчдод бүх төрлийн холбоо, мэдээллийн хэрэгсэл ашиглан жагсаал, цуглааныг албадан тараах тухай шийдвэрийг мэдэгдэнэ.

13.8.Албадан тараах шийдвэрийг мэдэгдсэний дараа оролцогчдод сонсогдохуйц чанга яригчаар тодорхой хугацаа өгч гурваас дээш удаа сануулсны дараа албадан тараана.

13.9.Жагсаал, цуглааныг албадан тараах, хүчирхийллийн шинжтэй үйлдэл гаргасан оролцогчид эрх бүхий байгууллагаас хуульд заасан арга хэмжээ авах үед хууль зүйн туслалцаа авах эрхийг хангана.

13.10.Албадан тараах ажиллагааны явцыг дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг ашиглан баримтжуулна.

13.11.Хууль сахиулах, тусгай чиг үүргийн байгууллагууд жагсаал, цуглаанд оролцсон хүний хувийн мэдээллийг тэднийг мөрдөн мөшгөх, жагсаал, цуглаан хийх эрхээ хэрэгжүүлсэнтэй нь холбогдуулан хууль бусаар ашиглахыг хориглоно.

13.12.Цагдаагийн байгууллагаас жагсаал, цуглааныг албадан тараах шийдвэрийг хэрэгжүүлсэн тохиолдолд тухайн арга хэмжээг хэрэгжүүлснээс хойш даруй олон нийтэд мэдээлнэ.

14 дүгээр зүйл.Жагсаал, цуглааны явц нээлттэй ил тод байх, гомдол гаргах

14.1.Иргэн жагсаал, цуглаан хийх эрхтэй холбоотой гомдол, мэдээллийг төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргах эрхтэй.

14.2.Энэ хуулийн 8.6-д заасан жагсаал, цуглаан хийхийг бүртгэхээс татгалзсан шийдвэрийг зохион байгуулагч үндэслэлгүй гэж үзвэл шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор дээд шатны цагдаагийн байгууллагад гомдол гаргаж болно.

14.3.Энэ зүйлийн 14.2 дахь хэсэгт заасан гомдлыг эрх бүхий албан тушаалтан ажлын 3 өдрийн дотор багтаан хянан шийдвэрлэнэ.

14.4.Жагсаал, цуглаан зохион байгуулагч нь дээд шатны цагдаагийн байгууллагаас гаргасан бүртгэхээс татгалзсан шийдвэр хүлээн авсан зохион байгуулагч түүнийг хуульд нийцэхгүй байна гэж үзвэл гомдлоо уг шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор шүүхэд гаргана.

14.5.Энэ зүйлийн 14.4-т заасан гомдлыг шүүгч ажлын 6 өдрийн дотор багтаан хянан шийдвэрлэнэ.

14.6.Шүүгч жагсаал, цуглаан хийхийг бүртгэхээс татгалзсан цагдаагийн байгууллагын шийдвэрийг хүчингүй болгосон бол зохион байгуулагч нь шүүгчийн захирамжийг хүлээн авсны дараа энэ тухай тухайн цагдаагийн байгууллагад урьдчилан мэдэгдэж жагсаал, цуглаан хийх хугацааг тохиролцож зохион байгуулж болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗОХИЦУУЛАЛТ

15 дугаар зүйл.Өлсгөлөн, суулт, түүнтэй холбоотой зохицуулалт

15.1.Өлсгөлөн зарласан хүний эрүүл мэндэд тухайн нутаг дэвсгэрийн Эрүүл мэндийн байгууллага үзлэг хийж, хяналт тавина.

15.2.Өлсгөлөн зарласан этгээдийн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрахаар байгаа нь эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон бол өлсгөлөнг зогсоож албадан эмчилгээнд оруулах арга хэмжээ авах шийдвэрийг тухайн нутаг дэвсгэрийн Эрүүл мэндийн байгууллагын дарга гаргаж, эмнэлгийн байгууллагад хүргэх ажлыг зохион байгуулна.

15.3.Өлсгөлөн, суулт зарлахыг хөндлөнгөөс албадахыг хориглоно.

15.4.Суулт хийж байгаа этгээдэд саад учруулахгүй байж, аюулгүй байдлыг нь хангана.

15.5.Өлсгөлөн зарласан хүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журмыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

15.6.Өлсгөлөн, суулт хийх хэлбэрээр олон нийтийн газар үзэл бодлоо илэрхийлэхэд энэ хуулийн 8.1, 8.2-т заасан мэдэгдэл хүргүүлэх, энэ хуулийн 12.3-т заасан албадан тараах зохицуулалт тус тус хамаарахгүй.

16 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

16.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

16.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.1994 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ДАЙНЫ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Дайны байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.1 дэх заалтын “зохих байгууллагын зөвшөөрөлгүйгээр хурал, цуглаан, жагсаал,” гэснийг “эрх бүхий этгээдэд мэдэгдээгүй жагсаал, цуглаан,” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ДОТООДЫН ЦЭРГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Дотоодын цэргийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2.6 дахь заалтын “хүч хэрэглэсэн жагсаал, цуглааныг” гэснийг “хууль бус жагсаал, цуглааныг” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“5.8 дугаар зүйл.Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль зөрчих

1.Хуулиар хориглосон газарт эсхүл, хуулиар хориглосон зорилгоор, эсхүл хуулиар зөвшөөрснөөс бусад этгээд жагсаал, цуглаан зохион байгуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Хуульд заасан эрх бүхий этгээдэд мэдэгдээгүй жагсаал, цуглаан зохион байгуулсан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Хуульд заасан журмын дагуу жагсаал, цуглаан зохион байгуулахад зориудаар саад учруулсан бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн, сэтгэцийн эмгэгийн улмаас өөрийн үйлдлийн бодит шинж чанар, аюулыг ухамсарлах, өөрийн үйлдлээ удирдан жолоодох чадваргүй хүнийг жагсаал, цуглаанд зориудаар татан оролцуулсан, эсхүл жагсаал, цуглаанд оролцуулахын тулд бусдыг эд мөнгөөр татах, дарамт шахалт үзүүлэх хэлбэрээр албадсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Жагсаал, цуглааныг зохион байгуулагч, оролцогч зэвсэг, хорт бодис, тэсэрч дэлбэрэх бодис, орчин тойрон, хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулж болохуйц аливаа зүйл, амьтан авч явсан бол зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгслийг хурааж, учруулсан хохиролыг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний

төгрөгөөр торгох, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Цагдаагийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 44.4 дэх хэсэг нэмсүгэй:

“44.4.Жагсаал, цуглааныг албадан тараах шийдвэрийг хэрэгжүүлэхэд Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хуульд заасан зохицуулалтыг баримтална.”

2 дугаар зүйл.Цагдаагийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсгийн “сум, дүүргийн Засаг даргын шийдвэрийг” гэснийг “эрх бүхий этгээдийн шийдвэрийг” гэж, 54 дүгээр зүйлийн 54.2.6 дахь заалтын “хүч хэрэглэсэн “жагсаал, цуглаан” гэснийг “хууль бус жагсаал, цуглаан,” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг